



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2021/3/СТА-БСД

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2021 он

Тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас:70359826

Цахим хаяг:orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас:70355805

Цахим хаяг:erdeneb@audit.gov.mn

Аудитор: Б.Азжаргал

Утас:70350757

Цахим хаяг:azjargalb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	15
Аудитын зөвлөмж.....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	16
4. Менежментийн захидал	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.03.16 № 94
танай _____-ны № _____-т

“МӨНХИЙН ГЭГЭЭ” ӨРХИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Г.МЯДАГХАНД ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол “Мөнхийн гэгээ” Өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга тогилуулсан байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал:

1. Бараа материал худалдан авах орлого, зарлага, хүлээн авсан хүлээлгэн өгсөн баримтын бүрдэл хангалтгүй, гэрээ байгуулаагүй 9,021.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 6.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 "Анхан шатны

баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалт, хэсэг, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны маягт нөхөх заавар”-тай нийцэхгүй байна.

2. Тайлант онд 1,096.1 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг, 443.6 мянган төгрөгийн цалингийн авлага үүссэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3. Сахилгын шийтгэлтэй ажилтанд 176.2 мянган төгрөгийн үр дүн илүү бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.7-д “хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 3-д “илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

4. Шатахууны норм хүйтэн, дулааны улирлаас үл хамааран өөрчлөлтгүй, шатахуун зарцуулалтын жишиг нормоос 937.5 мянган төгрөгийн шатахууныг илүү тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэсэн заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар батлагдсан жишиг нормтой нийцэхгүй, иж бүрэн байх, тохилдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5. Тус байгууллага нь харилцах данснаасаа 7,800.0 мянган төгрөгийг мөнгөн кассаар дамжуулан бэлэн мөнгөөр ажил үйлчилгээ явуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэсэн заалт, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан мөнгөн кассын журмын 6.3-д “төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300,000 (гурван зуун мянга) төгрөг, тээвэр шатахууны хэмжээ 500,000 (таван зуун мянга) төгрөгөөс хэтрэхгүй байна” гэсэн заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх, тохилдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

6. Эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх 10,441.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа харьцуулалтын арга хэрэглээгүй шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5.1.3-д "босго үнэ" гэж бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгөөс хамааруулан тендер шалгаруулалтыг энэ хуульд заасан журмын дагуу явуулахад баримтлах үнийн дээд, эсхүл доод хязгаарыг", 5.1.9-д "үнэлгээний хороо" гэж энэ хуульд заасан журмын дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулах зорилгоор захиалагчийн байгуулсан ажлын хэсгийг", 8.1.1-д "харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар" гэсэн заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх, тохилдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,893,375.81</u>	<u>10,371,452.84</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	140,878.01	63,148.84
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	140,878.01	63,148.84
3121	Төгрөг	140,878.01	63,148.84
31213	Арилжааны банк дахь харилцах	140,878.01	63,148.84
33	АВЛАГА	-	443,597.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	443,597.00
35	БАРАА МАТЕРИАЛ	5,752,497.80	9,864,707.00
351	Түүхий эд материал	2,111,798.80	6,980,657.00
35110	Тусгай зориулалттай материал	173,800.00	3,936,289.00
35130	Эм боох материал	1,937,998.80	3,044,368.00
354	Хангамжийн материал	3,640,699.00	2,884,050.00
35410	Бичиг хэргийн материал	1,619,550.00	224,500.00
35420	Аж ахуйн материал	1,721,149.00	2,189,800.00
35440	Түлш, шатах тослох материал	300,000.00	250,000.00
35460	Хүнсний материал	-	219,750.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>45,743,896.03</u>	<u>115,943,247.28</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	45,743,896.03	115,943,247.28
392	Биет хөрөнгө	45,435,146.04	115,699,497.33
39203	Авто-тээврийн хэрэгсэл	30,384,000.00	30,384,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(17,395,666.63)	(20,840,666.59)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	64,780,311.00	137,791,806.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(41,142,389.20)	(47,951,862.45)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,062,700.00	17,439,150.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,923,218.98)	(6,497,049.88)
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,712,017.00	6,712,017.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,042,607.15)	(1,337,897.15)
393	Биет бус хөрөнгө	308,749.99	243,749.95
39301	Програм хангамж	325,000.00	325,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(16,250.01)	(81,250.05)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>51,637,271.84</u>	<u>126,314,700.12</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>6,233.00</u>	<u>1,096,098.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,233.00	1,096,098.00
413	Өглөг	6,233.00	1,096,098.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,096,098.00

“Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит			
4136	Бусад өглөг	6,233.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	6,233.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	51,631,038.84	125,218,602.12
51	Засгийн газрын хувь оролцоо	51,631,038.84	125,218,602.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	28,052,305.00	28,052,305.00
512	Хуримтлагдсан үр дүн	22,709,233.84	96,296,797.12
51210	Өмнөх үеийн үр дүн	22,709,233.84	22,709,233.84
51220	Тайлант үеийн үр дүн	-	73,587,563.28
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	869,500.00	869,500.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	51,637,271.84	126,314,700.12

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	191,716,152.00	346,563,653.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,383,713.00	61,603,504.40
120	Нийтлэг татварын бус орлого	3,383,713.00	1,071,989.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,383,713.00	1,071,989.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,383,713.00	1,071,989.00
122	Тусламжийн орлого	-	60,531,515.40
122001	Хандив тусламж /дотоод/	-	60,531,515.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	188,332,439.00	284,960,149.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	149,176,699.00	252,395,499.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	149,176,699.00	252,395,499.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,905,500.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,500,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,405,500.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	33,250,240.00	32,564,650.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	33,250,240.00	32,564,650.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	191,340,038.68	272,976,090.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	191,340,038.68	272,976,090.12

“Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит			
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	187,074,138.68	262,409,740.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	124,001,412.53	175,027,515.00
210101	Үндсэн цалин	124,001,412.53	175,027,515.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,261,811.82	10,513,435.84
210201	Тэтгэврийн даатгал	10,645,145.48	6,271,824.82
210202	Тэтгэмжийн даатгал	843,311.85	414,571.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	270,093.06	311,497.09
210204	Ажилгүйдлийн даатгал	239,602.47	71,438.39
210205	Эрүүл мэндийн даатгал	2,263,658.96	3,444,104.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,988,824.14	2,115,508.33
210301	Гэрэл, цахилгаан	1,138,824.14	1,265,508.33
210302	Түлш, халаалт	850,000.00	850,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,034,741.00	11,486,443.00
210401	Бичиг хэрэг	2,946,637.00	4,427,530.00
210402	Тээвэр, шатахуун	2,702,700.00	3,000,314.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	745,400.00	767,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	960,000.00	720,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,680,004.00	2,205,169.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	366,030.00
2105	Нормативт зардал	16,831,730.40	42,479,211.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,246,530.40	32,571,630.80
210502	Хоол, хүнс	3,285,200.00	7,874,581.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00	2,033,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	325,800.00	1,560,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	325,800.00	292,000.00
210604	Урсгал засвар	-	1,268,700.00
2107	Томилолт, зочны зардал	1,290,000.00	832,000.00
210702	Дотоод албан томилолт	1,290,000.00	832,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,885,109.00	2,638,060.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,524,499.00	837,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	540,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	122,960.00	63,660.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	23,650.00	81,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	64,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	1,115,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,454,709.79	15,756,866.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,656,952.00	3,447,003.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	958,750.00	1,121,269.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,839,007.79	11,188,594.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,265,900.00	10,566,350.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,265,900.00	10,566,350.00

“Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит			
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	3,688,250.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	-	213,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	1,778,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,265,900.00	4,887,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	376,113.32	73,587,563.28
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	376,113.32	73,587,563.28

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН			
			/Төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	196,655,556.00	292,682,691.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	196,655,556.00	292,682,691.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	149,176,699.00	252,395,499.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	149,176,699.00	252,395,499.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,905,500.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,500,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,405,500.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	41,573,357.00	40,287,192.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	8,323,117.00	7,722,542.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	33,250,240.00	32,564,650.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	192,382,973.69	280,278,440.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	192,382,973.69	280,278,440.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	179,602,056.69	261,989,548.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	124,813,040.53	175,911,403.59
210101	Үндсэн цалин	124,813,040.53	175,911,403.59
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,261,811.82	8,983,279.25

“Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210201	Тэтгэврийн даатгал	10,645,145.48	6,271,823.07
210202	Тэтгэмжийн даатгал	843,311.85	414,571.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	270,093.06	311,497.09
210204	Ажилгүйдлийн даатгал	239,602.47	71,437.65
210205	Эрүүл мэндийн даатгал	2,263,658.96	1,913,950.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,988,824.14	2,115,508.33
210301	Гэрэл, цахилгаан	1,138,824.14	1,265,508.33
210302	Түлш, халаалт	850,000.00	850,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,002,471.00	13,737,700.00
210401	Бичиг хэрэг	4,280,587.00	2,911,950.00
210402	Тээвэр, шатахуун	3,002,700.00	2,922,314.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	745,400.00	767,400.00
210404	Ном, хэвлэл	77,000.00	150,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	960,000.00	720,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,472,424.00	5,778,486.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	464,360.00	487,550.00
2105	Нормативт зардал	17,954,611.20	43,428,871.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,369,411.20	33,459,110.00
210502	Хоол, хүнс	3,285,200.00	7,945,761.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00	2,024,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,323,600.00	10,945,150.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,043,600.00	600,000.00
210602	Тавилга	280,000.00	9,076,450.00
210604	Урсгал засвар	-	1,268,700.00
2107	Томилолт, зочны зардал	1,290,000.00	832,000.00
210702	Дотоод албан томилолт	1,290,000.00	832,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,989,609.00	2,745,260.00

“Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит			
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,692,999.00	837,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	540,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	122,960.00	63,660.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	23,650.00	81,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	1,222,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,978,089.00	3,290,376.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,291,789.00	2,169,107.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	686,300.00	1,121,269.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,780,917.00	18,288,892.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,780,917.00	18,288,892.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	8,323,117.00	7,722,542.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	191,900.00	3,688,250.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	-	213,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	1,778,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,265,900.00	4,887,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,272,582.31	12,404,250.83
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,105,000.00	12,481,980.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,105,000.00	12,481,980.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,105,000.00	12,481,980.00
222001	Тоног төхөөрөмж	-	12,481,980.00
223001	Бусад хөрөнгө	5,105,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(5,105,000.00)	(12,481,980.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(832,417.69)	(77,729.17)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		140,878.01
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	(832,417.69)	63,148.84

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	28,052,305.00	869,500.00	22,709,233.84	51,631,038.84
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	28,052,305.00	869,500.00	22,709,233.84	51,631,038.84
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	28,052,305.00	869,500.00	22,709,233.84	51,631,038.84
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	28,052,305.00	869,500.00	22,709,233.84	51,631,038.84
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	28,052,305.00	869,500.00	22,709,233.84	51,631,038.84
D08	Тайлант үеийн үр дүн			73,587,563.28	73,587,563.28
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	28,052,305.00	869,500.00	96,296,797.12	125,218,602.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд “Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Г.Мядагханд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 25-наас 2020 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Орхон аймаг дахь төрийн аудитын менежер Б.Эрдэнэ, аудитор Б.Азжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 02 сарын 25-ний өдрийн 25 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

“Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Эрхэм зорилго: “Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төв нь “Эрүүл мэндийн анхан шатны цогц тусламжийг MNS:5292:2017 стандартыг бүрэн хангаж үзүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна.

Үүнд:
 Эрүүл мэндийн тухай хууль
 Төсвийн тухай хууль
 Хөдөлмөрийн тухай хууль
 Эрүүл, мэнд нийгмийн даатгалын тухай хууль
 Эрүүл мэндийн газрын даргын тушаал
 Засаг даргын захирамж
 Өрхийн эрүүл мэндийн төвийн дотоод дүрэм, журам, стандартууд
 Бусад хууль тогтоомжууд

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

“Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн нийт орлого 133,557.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,335.6 мянган төгрөгөөр тооцсон ба гүйцэтгэлийн үе шатанд хувь хэмжээг өөрчлөөгүй бөгөөд нийт орлого 346,563.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,465.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тогтоолоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

“Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 74,677.5 мянган төгрөгөөр буюу 24.46 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	140.9	63.1	-77.8
Авлага		443.5	443.5
Урьдчилгаа			
Бараа материал	5,752.5	9,864.7	4,112.2
Үндсэн хөрөнгө	45,743.9	115,943.2	70,199.3
Нийт хөрөнгө	51,637.2	126,314.7	74,677.5
Өр төлбөр		1,096.0	1,096.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	28,052.3	28,052.3	0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	51,637.2	125,218.7	73,581.5

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 9,864.7 мянган төгрөг болж 4,112.2 мянган төгрөгөөр өссөн нь Covid-19 халдвараас сэргийлэх, хариу арга хэмжээ авахад зориулан бэлэн байдлын нөөц бүрдүүлэлтэнд нэг удаагийн комбинзон, халад, маск, нүүрний хаалт, бээлий мөн ариутгалын бодис болох санитол, спирт, жавлин зэргийг худалдан авсанаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 115,943.2 мянган төгрөг болж 70,199.3 мянган төгрөгөөр өссөн нь өрхийн эмнэлэгийн үйл ажиллагааг хэвийн явуулахад өрхийн эмнэлгийн өргөтөл хийгдэж орон нутаг, улсын хандив болон өөрийн хөрөнгөөр тоног төхөөрөмж болон тавилга худалдан авсан нь шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

“Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төв нь Шанд багийн 768 өрхийн 2783 хүн ам, Даваат багийн 1482 өрхийн 4969 хүн ам, Рашаант багийн 384 өрхийн 1369 хүн ам нийт 9121 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлдэг бөгөөд нэг хүнд ноогдох зардлаар тооцон 2020 оны төсвийн төслөө 242,888.1 мянган төгрөгөөр төлөвлөж төсвийн ерөнхийлөн захирагчдаа хүргүүлсэн бөгөөд, 242,610.5 мянган төгрөгөөр батлагдаж ирсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгай зориулалтын шилжүүлгээр 252,395.5 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 32,564.6 мянган төгрөг, нийт 284,960.1 мянган төгрөгийн санхүүжилтийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

“Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төв нь тайлант хугацаанд оруулбал зохих 1 мэдээллээс хугацаандаа оруулсан 1 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

“Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 акт, 1 албан шаардлага 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт	Биелэлт	Зөрүү
----------	---------------------	---------	-------

“Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит							
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	396.5	1	396.5			
Албан шаардлага	1	6,534.6	1	6,534.6			
Зөвлөмж	2	2,930.0	2	2,930.0			
Нийт дүн	5	9,861.1	5	9,861.1			

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 29,915.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнээс 10,441.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага, 176.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 19,298.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

“Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Тус өрхийн эмнэлэгийн жолоочид сахилгын шийтгэлтэй үед үр дүнгийн урамшуулалд 176.2 мянган төгрөг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.7-д "хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй"- той тус тус нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Эмнэлэгийн тоног төхөрөмж нийлүүлэх худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа харьцуулалтын арга хэрэглээгүй "Их итгэлт түнш" ХХК-тай шууд гэрээ байгуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5.1.3 "босго үнэ" гэж бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгөөс хамааруулан тендер шалгаруулалтыг энэ хуульд заасан журмын дагуу явуулахад баримтлах үнийн дээд, эсхүл доод хязгаарыг", 5.1.9-д " "үнэлгээний хороо" гэж энэ хуульд заасан журмын дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулах зорилгоор захиалагчийн байгуулсан ажлын хэсгийг", 8.1.1-д "харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар" гэсэн заалттай тус тус нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 19,298.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

“Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төвд 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материал, хөрөнгийн тооллого хийх шаардлагатай гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Зардлын данстай холбоотой данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Орон тооны нярав байхгүйгээс шалтгаалан бараа материал худалдан авах орлого, зарлага, хүлээн авсан хүлээлгэн өгсөн, шаардах хуудаст гарын үсэг зураагүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй 9,021.0 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", НББ-ийн тухай хуулийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалт, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны маягтийг нөхөх заавар"-тай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах, холбогдох хууль тогтоомж зөрчих

1.3. Өгсөн зөвлөмж :

Цаашид анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, дутуу баримтаар гүйлгээ хийхгүй байх талаар зөвлөмж хүргүүллээ.

2. **Илрүүлэлт:** Шатахууны норм хүйтэн, дулааны улирлаас үл хамааран өөрчлөлтгүй, шатахуун зарцуулалтын жишиг нормоос өндрөөр шатахууныг тооцож 937.5 мянган төгрөг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар баталсан жишиг нормтой нийцэхгүй байна.

2.1. **Эрсдэл:** Төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах, холбогдох хууль тогтоомж зөрчих

2.2. Өгсөн зөвлөмж :

Автомашины шатахуун зарцуулалтын хэмжээг туршилт хийж баталгаажуулж, бодит зарцуулалтыг үнэн зөв тодорхойлж, шатахууныг зарцуулах.

3. **Илрүүлэлт:** Тус байгууллага нь харилцах данснаасаа 7,800.0 мянган төгрөгийг мөнгөн кассаар дамжуулан зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалт, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан мөнгөн кассын журмын 6.3-д "төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн

дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300,000 (гурван зуун мянга) төгрөг, тээвэр шатахууны хэмжээ 500,000 (таван зуун мянга) төгрөгөөс хэтрэхгүй байна"-тай нийцэхгүй байна.

3.1. Эрсдэл:

Хөрөнгө шамшигдах, хяналт алдагдах, хууль тогтоомж зөрчих.

3.2. Өгсөн зөвлөмж:

Бэлэн мөнгөөр ажил үйлчилгээ явуулж зарлага гаргахдаа Сангийн сайдын 276 дугаар тушаалаар баталсан мөнгөн кассын журмын 6.3 дахь хэсгийг хэрэгжүүлж ажиллах.

4. Илрүүлэлт:

Тайлант онд 1,096.1 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг, 443.6 мянган төгрөгийн цалингийн авлага, нийт 1,539.7 мянган төгрөгийн өр авлага үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

4.1. Эрсдэл:

Хөрөнгө шамшигдах, хяналт алдагдах, хууль тогтоомж зөрчих.

4.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, авлага, өр төлбөргүй ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төсвийн захирагчийн 2021.03.15-ны өдрийн 16 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ :

Бэлтгэсэн: Аудитор

Б.Азжаргал Огноо

Анхан шатанд хянасан: Аудитын менежер

Б.Эрдэнэ Огноо

Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор

Ц.Нармандах Огноо

“Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төсвийн захирагчийн 2021.03.15-ны өдрийн 16 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ :

Бэлтгэсэн: Аудитор

Анхан шатанд хянасан: Аудитын менежер

Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор

Б.Азжаргал Огноо

Б.Эрдэнэ Огноо

Ц.Нармандах Огноо



ОРА-2021/3/СТА-БСД

16

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.03.03	Аудитын нэр:	“Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит			Аудитын код: СТА-2021/3/СТА-БСД
Шалгагдсан байгууллагын нэр:		“Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төв			424.6 мянган төгрөг
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	6
1	Шатахууны норм хүйтэн, дулааны улирлаас үл хамааран өөрчлөлтгүй, шатахуун зарцуулалтын жишиг нормоос өндрөөр шатахууныг тооцож олгосон байна.	937.5	Зөвлөмж	“Мөнхийн гэгээ” ӨЭМТ-ийн дарга нягтлан бодогч	Г.Мядагханд Б.Оюун-Эрдэнэ
2	Тус өрхийн жолоочид сахилгын шийтгэлтэй үед үр дүнгийн урамшуулал илүү олгосон	176.2	Төлбөрийн акт	“Мөнхийн гэгээ” ӨЭМТ-ийн дарга нягтлан бодогч	Г.Мядагханд Б.Оюун-Эрдэнэ
3	Орон тооны нярав байхгүйгээс шалтгаалан бараа материал худалдан авах орлого, зарлага, хүлээн авсан хүлээлгэн өгсөн, шаардах хуудаст гарын үсэг зураагүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй	9,021.0	Зөвлөмж	“Мөнхийн гэгээ” ӨЭМТ-ийн дарга нягтлан бодогч	Г.Мядагханд Б.Оюун-Эрдэнэ
4	Тайлант онд 1,096.1 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг, 443.6 мянган төгрөгийн цалингийн авлага үүссэн байна.	1,539.7	Зөвлөмж	“Мөнхийн гэгээ” ӨЭМТ-ийн дарга нягтлан бодогч	Г.Мядагханд Б.Оюун-Эрдэнэ
5	Тус байгууллага нь харилцах данснаасаа мөнгөн кассаар дамжуулан бэлэн мөнгөөр ажил үйлчилгээ явуулсан байна.	7,800.0	Зөвлөмж	“Мөнхийн гэгээ” ӨЭМТ-ийн дарга нягтлан бодогч	Г.Мядагханд Б.Оюун-Эрдэнэ

"Мөнхийн гэгээ" өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	Эмнэлэгийн тоног төхөрөмж нийлүүлэх худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа харьцуулалтын арга хэрэглээгүй "Их итгэлт түнш" ХХК-тай шууд гэрээ байгуулсан.	10,441.0	Албан шаардлага	"Мөнхийн гэгээ" ӨЭМТ-ийн дарга нягтлан бодогч	Г.Мядагханд Б.Оюун-Эрдэнэ
ДҮН		29,915.4			

Бэлтгэсэн: Аудитор

Б.Азжаргал Огноо

Анхан шатанд хянасан: Аудитын менежер

Б.Эрдэнэ Огноо

Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор

Ц.Нармандах Огноо

"Мөнхийн гэгээ" өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

"Мөнхийн гэгээ" өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит					
				нягтлан бодогч	
6	Эмнэлэгийн тоног төхөрөмж нийлүүлэх худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа харьцуулалтын арга хэрэглээгүй "Их итгэлт түнш" ХХК-тай шууд гэрээ байгуулсан.	10,441.0	Албан шаардлага	"Мөнхийн гэгээ" ӨЭМТ-ийн дарга нягтлан бодогч	Г.Мядагханд Б.Оюун-Эрдэнэ
ДҮН		29,915.4			

Бэлтгэсэн: Аудитор

Анхан шатанд хянасан: Аудитын менежер

Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор

Б.Азжаргал

Огноо 9/12

Б.Эрдэнэ

Огноо

Ц.Нармандах

Огноо



ОРА-2021/3/СТА-БСД

18

БАТЛАВ.
ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР /Ц.НАРМАНДАХ/

/гарын үсгийн тайлал/

8117143600

CA 40073 8042506

2021 оны 03 дугаар сарын 12

Орхон аймаг

МЭДЭГДЭЛ

“Мөнхийн гэгээ” ӨЭМТ-д

Сонсох ажиллагаа явуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.” гэж заасны дагуу асуудлын бүртгэлд албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоохоор тусгагдсан алдаа зөрчилд албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох болсон тул Захиргааны Ерөнхий хуульд заасны дагуу 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 16:00 цагт сонсох ажиллагааг биечлэн уулзах хэлбэрээр явуулах болсныг үүгээр мэдэгдэж байна.

Сонсох ажиллагаа нь дараах дарааллаар явагдана. Үүнд:

1. Захиргааны шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэлийг танилцуулах;
2. Захиргааны шийдвэр гаргах асуудлын талаарх үндэслэл, шалтгаан нөхцөлийг танилцуулах;
3. Санал сонсох.

Мэдэгдлийг гардуулж өгсөн:

Аудитор _____ /Б.Азжаргал/

албан тушаал гарын үсэг

Мэдэгдлийг хүлээн авсан:

“Мөнхийн гэгээ” ӨЭМТ-н ня-бо _____ /Б.Оюун-Эрдэнэ/

албан тушаал гарын үсэг

Мэдэгдлийг гардуулж өгсөн огноо: 2021.03.12

СОНСОХ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ТУХАЙ
ТЭМДЭГЛЭЛ

№ 06

2021 оны 03-р сарын 13-ны өдөр

Орхон аймаг

Захиргааны ерөнхий хуулийн дагуу “Мөнхийн гэгээ” ӨЭМТ-ийн дарга, нягтлан бодогч нарт 2021 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 11 цагт Нутгийн удирдлагын ордны 304 тоот албан өрөөнд биечлэн уулзах хэлбэрээр сонсох ажиллагааг явууллаа.

Сонсох ажиллагаанд байгууллагыг төлөөлж:

Албан тушаал, нэр;

Албан тушаал, нэр;

Сонсох ажиллагааны бүрэлдэхүүнээс татгалзал бий эсэх:

Татгалзаж байгаа шалтгаан: _____
_____ гарын үсэг _____

Бүрэлдэхүүнийг зөвшөөрч байна. Гарын үсэг _____

Сонсох ажиллагаа явуулах болсон шалтгаан: Мэдэгдэлд дурдагдсан захиргааны шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэл, Захиргааны шийдвэр гаргах тухайн асуудлын талаарх шалтгаан нөхцөл, үндэслэл, мэдээллийг “Мөнхийн гэгээ” ӨЭМТ-ийн дарга, нягтлан бодогчид танилцуулав.

Асуулт, хариулт: Асуудлын бүртгэлээр танилцуулсан акт тогтоох, албан шаардлага өгөх алдаа зөрчилтэй асуудалтай холбоотой санал тайлбар байна уу?

Асуудлуудтай танилцсан холбогдох санал, тайлбар байхгүй, цаашид анхаарч ажиллах болно.

_____ Сонсох ажиллагааг _____ 11:00 _____ цагт дуусгав.

Сонсох ажиллагаанд оролцсон:

Захиргааны төлөөлөл: Аудитор _____ /Б.Азжаргал/

Оролцогч: “Мөнхийн гэгээ” ӨЭМТ-ийн дарга Т.Мядагханд /Б.Оюун-Эрдэнэ/

Нягтлан бодогч





ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 57/57 ОМ-2021/3/ СТА-БСА Эрдэнэт хот

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сахилгын шийтгэлтэй ажилтанд үр дүнгийн урамшуулалд 176.2 мянган төгрөг илүү бодож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.7-д "хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Сахилгын шийтгэлтэй ажилтанд илүү олгосон үр дүнгийн урамшуулал 176.2 мянган төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 тоот /Ор.Хүү торгуулийн орлого/ дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2021 оны 05 дугаар сарын 25-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг “Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Г.Мядагханд, нягтлан бодогч Б.Оюун-Эрдэнэ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:.....

Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР:.....

Б.ЭРДЭНЭ

АУДИТОР:.....

Б.АЗЖАРГАЛ



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 98/98 ОАН-2021/3/СТН-БСД Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Мөнхийн гэгээ” Өрхийн эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх 10,441.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа харьцуулалтын арга хэрэглээгүй шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5.1.3-д "босго үнэ" гэж бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгөөс хамааруулан тендер шалгаруулалтыг энэ хуульд заасан журмын дагуу явуулахад баримтлах үнийн дээд, эсхүл доод хязгаарыг", 5.1.9-д " "үнэлгээний хороо" гэж энэ хуульд заасан журмын дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулах зорилгоор захиалагчийн байгуулсан ажлын хэсгийг", 8.1.1-д "харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх 10,441.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа харьцуулалтын арга хэрэглээгүй шууд гэрээ байгуулсан зөрчлийг арилгаж биелэлтийг 2021 оны 05 дугаар сарын 25-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг “Мөнхийн гэгээ” Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Г.Мядагханд, нягтлан бодогч Б.Оюун-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН

МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ

АУДИТОР: Б.АЗЖАРГАЛ

